



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ



УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

БАГАНУУРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙН БҮС НУТГИЙН ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот

2019 оны 7 дугаар сар

АГУУЛГА

1. УДИРТГАЛ.....	3
2. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОРИЛГО, ҮЕ ШАТ	4
3. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ	5
a. Хэлэлцүүлгийн талаар урьдчилсан байдлаар мэдээлэл өгөх, хэлэлцүүлгийн материал тараалт.....	5
b. Мэдээллийн ил тод байдал	6
c. Цахим хуудсан дээрх зар	8
d. Илтгэл бэлтгэсэн байдал	8
e. Санал авах журнал/дэвтэр	8
4. ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД.....	8
5. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАРААХ ҮЕ ШАТ.....	10
5.1. Оролцогч талуудаас гарсан гол зөвлөмжүүд:	10
5.2. Оролцогч талуудын саналуудыг ХНҮ-ний тайлангийн төсөлд тусгах нь	10

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хуваарь	6
Хүснэгт 3. Хэлэлцүүлгийн багц материалууд	7
Хүснэгт 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлгийг зарласан байдал.....	7
Хүснэгт 5. Зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүдийн хуваарь	9
Хүснэгт 6. Хэлэлцүүлгийг багийн бүрэлдэхүүн.....	9

ТОВЧЛОЛ

ААН	Аж ахуй нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНЧБХ	Байгаль орчин, нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг
ДБ	Дэлхийн банк
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХ	Олон нийтийн хэлэлцүүлэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УУДБХОДТ	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл
ХНҮ	Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШҮ	Шинжлэх ухаан

1. УДИРТГАЛ

Монгол улсад эрчим хүчний онцгой чухал эх үүсвэр нь нүүрс юм. Монгол улсын дотоодын нүүрсний олборлолтын талаас илүү хувийг бүрдүүлж байгаа Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын өндөр чанарын нүүрсний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх нь чухал байна. Эдгээр уурхайнуудын саяхан хийсэн судалгаагаар 800сая тонн нүүрсний нөөцтэй гэсэн шинэчилсэн тооцоог гаргасан нь байна үүний өмнөх тооцоогоор 600сая тонноос бага нөөцтэй гэж үзэж байсан.

УУДБХОДТ төсөл нь Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг хариуцан гүйцэтгэсэн. Төслийн санхүүжилттэй холбоотой байгаль орчны болон нийгмийн нийцлийн үнэлгээний төслийн нэг хэсэг болох хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь санал болгож буй Багануурын нүүрсний уурхайн өргөтгөл нь байгаль орчин, нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд (БОНЧБХ) хэрхэн нөлөөлөхийг судлах шаардлагатай.

Тиймээс 2012 онд УИХ-аар батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд Засгийн газрын 2013 оны 374 тоот тогтоол, 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн баталсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын стратеги, Дэлхийн банкнаас санхүүждэг "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл" (УУДБХОДТ) -ийн дагуу хоёр бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ шаардлагатай.

УУДБХОД төслийн хүрэн дэх хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зорилго нь:

"... Багануур" нүүрсний уурхайн хуримтлагдах нөлөөлөл, эрсдэлийг үнэлэхийн тулд өнгөрсөн, одоо болон ирээдүйн төсөл, арга хэмжээнүүд, бүс нутгийн сонгогдсон БОНЧБХ-д байгаль орчин, нийгмийн талаас нөлөөлж болзошгүй хүчин зүйлийг авч үзэн, хуримтлагдсан нөлөөг бууруулах менежментийн арга хэмжээг төлөвлөх."

Дээрх зорилгын дагуу "Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг 2015 онд Нэйчурал састэйнэйбл ХХК боловсруулсан байдаг. Энэхүү тайлангийн сонирхогч талуудын санал, зөвлөмжийг тусгасан шинэчилсэн хувилбарыг боловсруулах шаардлага тулгарсан.

"Багануурын уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлан" -нд нэмэлт өөрчлөлтийг хийх зорилгоор "Грийнтрендс" ХХК нь УУДБХОДТ -ийн дараах ажлуудыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Үүнд:

- Арга зүйг хянан үзэж, шинэчлэх;
- Бүс нутгийн суурь өгөгдлийг нэгтгэх, дахин үнэлэх, шинэчлэгдсэн шалгуур үзүүлэлт дээр тулгуурлан БОНЧБХ-ийг дахин үнэлэх, орон зайн болон цаг хугацааны хил хязгаарыг дахин тодорхойлох, хуримтлагдах нөлөөллийг дахин үнэлэх, дүн шинжилгээ хийх, чиг хандлага, зам, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн менежмент, мониторингийн хөтөлбөрүүдийг боловсруулах;
- Тайлангийн бүтэц, ойлгомжтой байдлыг сайжруулах, бүтэц зохион байгуулалт, үг хэллэг, найруулга зүйн байдлыг сайжруулах.

Дэлхийн Банкны Олон нийтийн хэлэлцүүлэг, Мэдээллийн нээлттэй байдлын журам болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах

тухай журмын дагуу Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний (ХНҮ) тайлангийн төслийг тухайн бүс нутагт хамаарагдах орон нутагт ил тод, нээлттэй болгож, холбогдох талуудаар хэлэлцүүлэн, ХНҮ-ний тайлангийн төсөлд тэдгээрийн санал зөвлөмжийг авч үзсэн болно.

Энэхүү тайланд олон нийтийн хэлэлцүүлгийн зорилго, хэлэлцүүлгийн бэлтгэл үе шат, хэлэлцүүлгийн талаар урьдчилсан байдлаар мэдээлэл өгөх, хэлэлцүүлгийн материал тараалт, мэдээллийн нээлттэй байдал, хэлэлцүүлгийн явц, хэлэлцүүлгийн дараах үе шат, талуудын саналыг Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний (ХНҮ) тайлангийн төсөлд хэрхэн тусгасан, талуудаас хүлээн авсан гол саналууд, хэлэлцүүлгийн үр дүнг нээлттэй болгох, цаашид авах арга хэмжээнүүдийн талаар дэлгэрэнгүй тусгав.

2. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОРИЛГО, ҮЕ ШАТ

Тус хэлэлцүүлгийн зорилго нь Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн талаарх холбогдох талуудад мэдээлэл өгөх, тэдгээрийн дунд хэлэлцүүлэн, санал зөвлөмж авах, боломжит саналуудыг тайлангийн төсөлд тусган, сайжруулж, эцэслэн боловсруулах зорилготой.

Энэ удаагийн хэлэлцүүлэг нь 2019 оны 06-р сарын 25 болон 26-ны өдрүүдэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, яамд, ААН, мэргэжлийн судалгаа шинжилгээний байгууллагууд болон орон нутгийн иргэд, малчдын дунд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт тухайн бүс нутагт хамрагдах сум, дүүргүүдийн ЗДТГ, ИТХ, ЗДТГ-ийн Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн газар зохион байгуулалт, Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, байгаль хамгаалагчид, Хэрлэн голын сав газрын захиргаа, Дулааны цахилгаан станцууд, ШУ-ны хүрээлэнгүүд, Их сургуулиуд, ТББ-ууд, иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутгийн иргэд, малчид зэрэг оролцогч талуудыг хамруулан, тэдгээрийн санал бодлыг сонсох нь зайлшгүй бөгөөд энэ нөхцөлийг хангаж ажилласан.

Оролцогчдын нэрс болон аливаа байгууллагад харьяалагдах байдлыг нээлттэй болгохтой холбоотой зарчим: Хэлэлцүүлэгт оролцсон бүх оролцогчдын зөвшөөрөлгүйгээр нэрсийг олон нийтэд нээлттэй болгох боломжгүй учир ирүүлсэн бүх саналыг асуулт, хариултын хүснэгтэд нэрсийг нууцлан оруулж шударгаар хянаж үзнэ.

Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөлд саналыг тусгах тухай зарчим: Асуулт, хариултын хүснэгтийн зорилго нь ХНҮ-ний тайлангийн төсөлд ирүүлсэн санал, зөвлөмжүүдийг хэрхэн тайлангийн төсөлд тусгагдсаныг харуулах зорилготой. Бүх санал, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, хүлээн авна гэсэн үг биш бөгөөд санал, зөвлөмж тус бүрийг хэрхэн авч үзсэн, саналыг хүлээж аваагүй бол үндэслэлийг тайлбарлана.

Олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулахад дараах үе шатуудыг хэрэгжүүлнэ:

1. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажил,
2. Хэлэлцүүлгийг зарлах, мэдээллийг нээлттэй, ил тод болгох,
3. Олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах,

4. Хэлэлцүүлгээс гарсан саналуудыг үнэлж (амаар, саналын хуудсаар, саналын дэвтрээр) ХНҮ-ний тайлангийн төсөлд тусгах, саналуудыг хэрхэн тусгасан эсэхийг Хариултын хүснэгтээр үзүүлэх,
5. Хэлэлцүүлгийн тайлан болон холбогдох материалуудыг бэлтгэж, олон нийтэд нээлттэй болгох.

3. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

Олон нийтийн хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг Байгаль орчин, Усны менежмент хариуцсан мэргэжилтэн Т.Цэцгээ, Талуудын оролцоо, Олон нийт хариуцсан мэргэжилтэн О. Алтай, “Грийнтрэндс” ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал Б. Баяржаргал болон ХНҮ-ний тайлангийн төслийг боловсруулж буй зөвлөх багийн гишүүд нар оролцон гүйцэтгэсэн болно.

а. Хэлэлцүүлгийн талаар урьдчилсан байдлаар мэдээлэл өгөх, хэлэлцүүлгийн материал тараалт

Дэлхийн Банкны Олон нийтийн хэлэлцүүлэг, Мэдээллийн нээлттэй байдлын журам болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд Олон нийтийн оролцоог хангах тухай журам болон төслийн Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөөний дагуу доорх ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэв.

ҮЕ ШАТ I: Хэлэлцүүлгийн бэлтгэл үе шат ба хэлэлцүүлгийн талаар урьдчилан мэдээлэл өгөх үе шатанд:

1. УУДБХОДТөслийн ТХН, Зөвлөх баг хамтран хэд хэдэн уулзалт зохион байгуулж, төслийн хэлэлцүүлгийн хамрах талбай, төслийн оролцогч талуудыг тодорхойлж жагсаалт гаргав. Ингэхдээ ХНҮ-ний тайлангийн төслийн бүс нутагт хамаарах Улаанбаатар хотын 1 дүүргийн 5 хороо, 1 аймгийн 1 сумдад хамаарах төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, малчид, аж ахуйн нэгжүүдийг хамрууллаа.
2. УУДБХОДТөсөл, Зөвлөх баг болон ДБ-ны зөвлөхүүдтэй хамтран хэлэлцүүлгийн гол материалууд болох ХНҮ-ний тайлангийн төсөл, Техникийн болон Техникийн бус хураангуйг боловсруулав. Мөн хэлэлцүүлгийн туслах материалууд болох хэлэлцүүлгийн зарлал, урилга, хөтөлбөр, илтгэл, хэлэлцүүлгийн сэдэв болон хэлэлцүүлгийн зохион байгуулалтад санал авах хуудас, хэлэлцүүлгээс өмнө болон хойш 14 хоногийн турш ЗДТГ болон ИТХ/ИНХ-д байршуулах санал авах дэвтэр, хэлэлцүүлгийн материал хүлээлцсэн маягт, бүртгэлийн хуудас, анонс, зурагт хуудас, түгээмэл асуултуудыг боловсруулав.
3. Нийслэлийн ЗДТГ, Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн агаарын бохирдол бууруулах газар болон дээр дурдсан 1 дүүрэг, 1 аймгийн 1 сум тус бүрд ЗДТГ-ын цахим шуудангаар хэлэлцүүлэг явуулахаас өмнө олон нийтийн хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг тухайн дүүрэг, сумын холбогдох талуудад урьдчилан өгөх, хэлэлцүүлгийн материалыг тараах уулзалтыг товлох талаарх мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны (БОАЖЯ) Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн 2019 оны 06 дүгээр сарын 06 –ны өдрийн 06а/3884 тоот албан бичгүүдийн хамт илгээсэн. 2019 оны 06 сарын 12 –ны өдрүүдэд бүх уулзалтуудыг товлов. (Хүснэгт 1. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хуваарь).

Товлосон уулзалтуудын дагуу УУДБХОДТөслийн ТХН, Зөвлөх багийн мэргэжилтэн зэргээс бүрдсэн баг 1 дүүргийн 5 хороо, 1 аймгийн 1 суманд орон нутгийн удирдлагууд болон мэргэжилтнүүд, иргэд, малчид, ТББ-ын төлөөлөл гэх мэт орон талын оролцоог хангасан төлөөллүүдтэй 2019 оны 06-р сарын 10, 12-ны өдрүүдэд уулзалт зохион байгуулан ажиллаж хэлэлцүүлгийн ач холбогдол, зорилгыг тайлбарлаж, хэлэлцүүлэгт яагаад идэвхтэй оролцох ёстой вэ, яагаад орон нутагтаа хэлэлцүүлгийн талаар сурталчлах үүрэг хүлээж байгааг тайлбарлахын зэрэгцээ хэлэлцүүлгийн материалуудыг тараан, огноог тохиролцон, хэлэлцүүлэг даргалагчийг тодорхойлов.

Хүснэгт 1. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хуваарь

Сум/дүүрэг	Огноо	Цаг
Төв аймгийн Баяндэлгэр	2019. 06.10	9:30
Улаанбаатар хотын Багануур дүүрэг	2019. 06.10	12:00
Улаанбаатар хотын Засаг даргын тамгын газар	2019.06.12	14:00

в. Мэдээллийн ил тод байдал

ҮЕ ШАТ II: Хэлэлцүүлгийг зарлах, мэдээллийг нээлттэй, ил тод болгох ажлын хүрээнд: 2019 оны 06 сарын 12-ны өдрөөс эхлэн урьдчилан тодорхойлсон байршлуудад нутгийн удирдлагын байранд, орон нутгийн ТВ, болон цахим хуудаснуудад мэдээллийг байршуулсан. Мөн хэлэлцүүлгийн зарыг хэд хэдэн телевиз, сонин, орон нутгийн цахим хуудаснуудаар дамжуулан түгээсэн. УУДБХОДТөслийн ТХН, “Грийнтрендс” ХХК нь хэлэлцүүлгийн холбогдох багц материалыг Монгол болон Англи хэл дээр боловсруулан бэлтгэж, хэлэлцүүлэг болохоос 14 хоногийн өмнө олон нийтэд нээлттэй болгон орон нутгийн болон УУДБХОДТөслийн цахим хуудсанд байршуулсан.

1. Энэхүү ажлын хүрээнд 1 дүүргийн 5 хороо, 1 аймгийн 1 сумын 50 гаруй иргэдтэй уулзаж мэдээлэл өгсөн бөгөөд хэлэлцүүлгийн багц материалыг хэлэлцүүлэг явуулахаас хангалттай хугацааны өмнө холбогдох талуудад биечлэн тараасан.
2. Холбогдох засаг захиргааны байгууллагууд тэр дундаа хороо болон багийн Засаг дарга нар, хэсгийн ахлагч нартай хэлэлцүүлгийн мэдээллийг урьдчилсан байдлаар иргэдэд хүргэх ажлыг хамтран гүйцэтгэсэн. Ингэхдээ бүх хороод, багийн Засаг дарга нарт доор дурдсан хэлэлцүүлгийн материалуудыг иргэдэд тараалгахаар хангалттай тоогоор хүлээлгэн өгч Хэлэлцүүлгийн материал хүлээлцсэн маягыг иргэдээр бөглүүлж гарын үсэг зуруулах зорилгоор хүлээлгэн өгөв.

Хэлэлцүүлгийн багц материалд:

- ✚ Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөл
- ✚ Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн Техникийн хураангуй,
- ✚ Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн Техникийн бус хураангуй багтсан болно.
- ✚ Санал авах дэвтэр

Дээр дурдсан хэлэлцүүлгийн багц материалуудыг хэвлэмэл хэлбэрээр санал авах дэвтрийн хамт орон нутгийн ЗДТГ болон Иргэний танхим, хороодуудад байршуулсан ба нийт Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөл 9 ш, төслийн техникийн хураангуй 180 ш, техникийн бус хураангуй 420 ш, санал авах дэвтэр 8 ш тараасан (Хүснэгт 2). /Дэлгэрэнгүйг Материал тараалтын тайлангаас үзнэ үү/.

Хүснэгт 2. Хэлэлцүүлгийн багц материалууд

Багц материалууд	БНБОУ-ний тайлангийн төсөл	Техникийн хураангуй	Техникийн бус хураангуй	Санал авах дэвтэр
Тоо ширхэг	9	180	420	8

2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр УУДБХОДТөслийн цахим хуудсанд хэлэлцүүлгийн урилга, хөтөлбөр болон хэлэлцүүлгийн материалуудыг Англи, Монгол хэлээр байршуулж хэлэлцүүлгийг албан ёсоор зарлав.

3. Мөн хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй зарыг холбогдох дүүрэг, сумын Фейсбүүк хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээв. (Хүснэгт 3)
4. Оролцогчдыг хэлэлцүүлэгт оролцох эсэхийг утсаар лавлан баталгаажуулав.
5. Хэлэлцүүлгийн сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулагдахаас өмнө 14 хоног, хэлэлцүүлэг явуулснаас хойш 14 хоногийн турш санал хүсэлт, зөвлөмжийг дараах сувгаар хүлээн авав.
 - Цахим хуудас: <http://minis.mn/mn/p/санал-авах-хуудас>
 - Шуудангийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Жамьян гүний гудамж 10, Ариг төв 401 тоот
 - Утас: +976 - 7011-2689, 99102722
 - Факс: +976 - 7011-2689
 - Фейсбүүк: <https://www.facebook.com/MinisProject/>
 - Twitter: <https://twitter.com/water47189300>
 - И-мэйл: admin@minis.mn , info@greentrends.mn

Дараах хүснэгтэд хэлэлцүүлгийн зарыг орон нутгийн сонин, ТВ зарласан байдлыг үзүүлээ.

Хүснэгт 3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлгийг зарласан байдал

Сонин дээрх зар				
№	Байршил	Сонины нэрс	Зар тавигдсан огноо	Зар тавигдсан огноо
1	Улаанбаатар	“Өдрийн сонин”	2019.06.17	2019.06.21
ТВ-ийн зар (урсдаг зар)				
№	Нэр	Огноо	Хэдэн өдөр	Давтамж
1	UBS ТВ	2019.06 сарын 13, 20, 22, 24	4 хоног	Өдөрт 2 удаа
2	Сүлжээ 3 ТВ	2019.06 сарын 13, 16,19,22,24,25	6 хоног	1 цаг тутамд
3	Малчин ТВ	2019.06 13,14,15,16,17,18,19,20,21,22,23,24,25	14 хоног	Өдөрт 2 удаа

с. Цахим хуудсан дээрх зар

УУДБХОДТөслийн цахим хуудсанд Англи, Монгол хэл дээрх зарыг харах боломжтой. Мөн заруудыг хэлэлцүүлэг зохион байгуулагдах дүүрэг, сум, хороодын боломжит цахим хуудас болон нэгдсэн зар түгээх фейсбүүк хуудас, группийг хамруулж түгээсэн (Хавсралт 10. Цахим зарлал).

d. Илтгэл бэлтгэсэн байдал

Илтгэлийг Монгол улсын болон Олон улсын бодлого, ХНҮ хийгдэх шаардлага, зорилго, ХНҮ-ний үе шатууд, ХНҮ, Байгаль орчин, нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн гол үр дүн, Хуримтлагдах нөлөөллийн үр дагаврыг үнэлэх, Нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, дүгнэлт гэсэн агуулгатайгаар Дэлхийн банк болон УУДБХОДТөслийн мэргэжилтнүүдийн зөвлөмжийн дагуу ХНҮ-ний тайлангийн агуулга, үр дүн дээр үндэслэн боловсруулав.

Илтгэлийг товч бөгөөд зураг, хүснэгт байдлаар иргэдэд ойлгомжтой, мэргэжлийн үг хэллэг аль болох ашиглахгүйгээр бэлтгэсэн. (Хавсралт 6. Илтгэл)

e. Санал авах журнал/дэвтэр

УУДБХОДТөслийн ТХН болон Зөвлөх баг хэлэлцүүлэг зохион байгуулагдах өдрөөс 14 хоногийн өмнө хэлэлцүүлгийн багц материалыг санал авах журналын хамт Хүснэгт 1. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хуваарь-т тусгасан дүүрэг, хороо, сумын ЗДТГ болон Иргэний танхимд байршуулсан бөгөөд оролцогч талуудыг хэлэлцүүлгийн дараа 14 хоногийн дотор саналаа өгөх боломжийг хангасан. Хэлэлцүүлэг тус бүр дээр хурал даргалагч нь саналын журналд бичгээр санал өгөх боломжтой тухай оролцогчдод мэдээлж байсан.

4. ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД

ХНҮ-ний Зөвлөх баг, УУДБХОДТөслийн ТХН болон Дэлхийн банкны төлөөллүүдээс бүрдсэн баг бүрэлдэхүүн 2019 оны 06-р сарын 25, 26-ны өдрүүдэд Багануурын нүүрсний уурхай бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хот, Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Төв аймгийн Баяндэлгэр сумыг хамруулан нийт 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн баг бүрэлдэхүүнийг Хүснэгт 5. Хэлэлцүүлгийг багийн бүрэлдэхүүн-ээс харна уу.

Хэлэлцүүлэгт оролцогчдыг бүртгэн гарын үсэг зуруулж, хэлэлцүүлгийн багц материалуудыг тараасны дараа УУДБХОДТөслийн талаар танилцуулга хийж, үүний дараагаар зөвлөх багийн төлөөллөөс Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн талаар илтгэлийг тавьсан бөгөөд илтгэлүүдтэй холбоотой асуулт хариултыг 60 минутад явуулсан. Асуулт хариултын дараа амаар саналуудыг авч, амаар санал өгч чадаагүй иргэдээс саналын хуудас бөглүүлж, хурааж авснаар хэлэлцүүлгийн үйл ажиллагаа өндөрлөсөн. Хэлэлцүүлгийн хөтөлбөрийг Хавсралт 3-аас үзнэ үү. Хэлэлцүүлгийн үйл явцтай холбоотой зургуудыг Хавсралт 4. Хэлэлцүүлгийн зургаас үзэж болно.

Хэлэлцүүлгийн товийг материал тараалтын ажлаар дүүрэг, сум бүрд очиж ажиллан товлосон бөгөөд

Хүснэгт 4. Зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүдийн хуваарь-н дагуу зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт Хүснэгт 1. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хуваарь-т тусгасан дүүрэг, хороо, сумын ЗДТГ, ИТХ, ЗДТГ-ийн Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн газар зохион байгуулалт, Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, байгаль хамгаалагчид, Хэрлэн голын сав газрын захиргаа, иргэд, малчид идэвхтэй оролцсон.

2 хэлэлцүүлэгт нийт дээрх төлөөллөөс бүрдсэн 126 хүн оролцсон бөгөөд хэлэлцүүлэг тус бүрийн оролцогчдын тоо болон төлөөллүүдийг Хавсралт 2. Оролцогчдын нэрсийн жагсаалт-аас харна уу.

Хэлэлцүүлэг зохион байгуулагдсан хот 1, дүүрэг 1, 2 байршлын байр, танхим, огнооны мэдээллийг

Хүснэгт 4-аас үзнэ үү:

Хүснэгт 4. Зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүдийн хуваарь

№	Танхим	Хуваарь, огноо	Үргэлжлэх хугацаа	Нийт оролцогчдын тоо	Хамруулсан сум, дүүргүүд
1	Улаанбаатар хотын Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв	2019. 06. 25, 14:00	3 цаг	28	
2	Улаанбаатар хотын Багануур дүүргийн Хурлын танхим	2019. 06. 26, 14:00	3 цаг	98	Төв аймгийн Баяндэлгэр сум

Хэлэлцүүлгийн төлөөлөгчид нь Багануурын нүүрсний уурхай бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн судалгааны эрдэмтэд, судлаачид болон мэргэжилтнүүдээс бүрдсэн баг зохион байгуулсан ба багийн бүрэлдэхүүнийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 5. Хэлэлцүүлгийг багийн бүрэлдэхүүн

Багийн бүрэлдэхүүн	
УУДБХОДТөсөл	Т.Цэцгээ, Байгаль орчин, усны менежмент хариуцсан мэргэжилтэн О.Алтай, Талуудын оролцоо, олон нийтийн харилцааны ажилтан
Зөвлөх багаас “Грийнтрэндс” ХХК	Б.Баяржаргал, Төслийн удирдагч Ш. Анармаа, Төслийн судлаач А.Ану-Үжин, Төслийн ахлах мэргэжилтэн Г.Өсөхбаяр, Төслийн мэргэжилтэн А.Дагийсүрэн, Төслийн мэргэжилтэн Т. Бадам, Төслийн мэргэжилтэн Н.Энхзаяа, Төслийн мэргэжилтэн Д. Оюунцэцэг, Төслийн судлаач Г.Түмэннаст, Төслийн судлаач

Хэлэлцүүлгийн асуулт, хариултын үед нутгийн иргэдийн эрүүл мэндийн асуудал, усны нөөц, орчны агаарын бохирдол, уурхайн тоосжилт, уурхайн өргөтгөлөөс үүсэх нүүлгэн шилжүүлэлтийн тухай асуудлуудыг асууж байсан.

5. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАРААХ ҮЕ ШАТ

Энэхүү хэлэлцүүлгийн дараах үе шатанд доорх ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- 1 дүүргийн 5 хороо, 1 аймгийн 1 суманд байршуулсан 8 саналын дэвтрийг 2019 оны 07-р сарын 10-ны өдөр цуглуулж дуусав.
- Мөн энэ өдөр **В. Мэдээллийн ил тод байдлын 5** –д заасан сувгуудаар нэмэлт саналуудыг хүлээн авч, санал авах хугацааг эцэслэв.
- Олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр аман болон бичгээр өгсөн саналууд, хэлэлцүүлгийн дараа 14 хоногийн турш бүх боломжит сувгуудаар ирүүлсэн нэмэлт саналуудыг нэгтгэн дүгнэж, үнэлээд ХНҮ-ний тайлангийн төслийн холбогдох хэсэгт тусгасан.
- Олон нийтийн хэлэлцүүлгийн тайланг дараах хавсралтуудын хамт боловсруулав.
 - ✚ Хавсралт 1: Зарлал
 - ✚ Хавсралт 2: Оролцогчдын нэрсийн жагсаалт
 - ✚ Хавсралт 3: Хөтөлбөр
 - ✚ Хавсралт 4: Зураг
 - ✚ Хавсралт 5: Хэлэлцүүлгийн тэмдэглэл
 - ✚ Хавсралт 6: Илтгэл
 - ✚ Хавсралт 7: Хэвлэлийн мэдээ
 - ✚ Хавсралт 8: Хариултын хүснэгт
 - ✚ Хавсралт 9: Сонингийн зарлал
 - ✚ Хавсралт 10: Цахим зарлал
- Дээрх бүх тайлан, материалуудыг Дэлхийн Банк болон УУДБХОДТөслийн нэгжид хүргүүлэн, хянуулан, эцэслэв.

5.1. Оролцогч талуудаас гарсан гол зөвлөмжүүд:

- ✚ Багануурын нүүрсний уурхайн шавхан зайлуулж байгаа усыг хуримтлуулан сан байгуулах
- ✚ Малын тоог бууруулж, малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлж, чанаржуулахын тулд малчдын мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгах
- ✚ Багануурын нүүрсний уурхайд ажиллагсдын мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн нөлөөллийн үр дагаврыг тооцох.
- ✚ Хүн амын өсөлт нэмэгдэж байгаа тохиолдолд нийгмийн дэд бүтцийн хүртээмж дагаж нэмэгдэхийг анхаарах хэрэгтэй.

5.2. Оролцогч талуудын саналуудыг ХНҮ-ний тайлангийн төсөлд тусгах нь

Олон нийтийн хэлэлцүүлгийн гол зорилго болох олон нийтэд мэдээлэл хүргэх, ХНҮ-ний тайлангийн төсөлд санал авах зорилгын хүрээнд доор дурдсан арга замуудаар ХНҮ-ний тайлангийн төсөлд санал, зөвлөмжүүдийг авсан.

1. Хэлэлцүүлгийн протокол - Нийт 2 байршилд зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн үед аудио, видео бичлэг хийх болон бичгээр тэмдэглэл хөтөлсөн бөгөөд байршил тус бүрийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс дэлгэрэнгүй үзэх боломжтой (Хавсралт 5. Хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл).

2. Санал авах хуудас-Хэлэлцүүлгийн үед өөрийн саналаа хэлж чадаагүй оролцогчдод саналаа өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор 2 төрлийн саналын хуудсаар нийт оролцогчдоос санал авсан.
3. Саналын дэвтэр - Материал тараалтын ажлын үеэр Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөлд орон нутгаас санал авах зорилгоор сум, дүүргийн нийт 8 ш саналын дэвтрүүдийг Иргэдийн нийтийн танхим болон сум орон нутгийн ЗДТГ, хороодод хэлэлцүүлэг зохион байгуулагдахаас 14 хоногийн өмнөөс эхлэн хэлэлцүүлэг зохион байгуулагдсаны дараа 14 хоногийн хугацаанд байршуулж олон талын төлөөллийн саналыг авсан.

Дээр дурдагдсан арга замаар буюу нийт 1 хот, 1 дүүргийн , 1 сумын төвөөс ирсэн саналын 8 ш дэвтэр, хэлэлцүүлгээс гарсан аман болон саналын хуудас, бичгээр өгсөн санал зөвлөмжүүдийг нэгтгэн боловсруулж, төлөвлөгөөнд тусгах боломжтой саналуудыг Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөлд тусгаж, хавсралтаар иргэдийн хамгийн их санал өгсөн газар, байршил зэргийг тодруулан оруулж өгсөн.

Дээрх нийт санал, зөвлөмжийг асуулт, хариултын хүснэгтийн тусламжтай хэрхэн ХНҮ-ний тайлангийн төсөлд туссан талаар хариулт өгсөн бөгөөд Хавсралт 8. Асуулт, хариултын хүснэгтээс харна уу.

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	Хэлэлцүүлгийн зар
Хавсралт 2.	Оролцогчдын нэрсийн жагсаалт
Хавсралт 3.	Хөтөлбөр
Хавсралт 4.	Хэлэлцүүлгүүдийн зураг
Хавсралт 5.	Хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл
Хавсралт 6.	Хэлэлцүүлгийн илтгэл
Хавсралт 7.	Хэвлэлийн мэдээ
Хавсралт 8.	Асуулт, хариултын хүснэгт
Хавсралт 9.	Сонинд гаргасан зар
Хавсралт 10.	Цахим хуудсанд гаргасан зарлал